



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ЗАМЫН ХӨГЖЛИЙН ГАЗАР

Нийслэлийн Засаг захиргааны II байр,
Ц.Жигжиджавын гудамж, 1 дүгээр хороо,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160-0088
Утас: (976-11) 32 53 85, Факс: (976-11) 32 44 98
Цахим шуудан: info@road.ub.gov.mn
Цахим хуудас: www.road.ub.gov.mn

2024.09.20 № 03/2257

танай _____ -ны № _____ -т

Тодруулга хүргүүлэх тухай

Нийслэлийн Засаг даргын 2024 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн А/842 дугаар захирамжаар батлагдсан "Авто зам, замын байгууламжийн засвар шинэчлэлтийн ажлын жагсаалт"-ын 28 дах (Алтан овооны замын уулзвараас Найрамдалын зам хүртэлх авто зам) ажлын төсөвт өртгийг 7,500,000,000 (долоон тэрбум таван зуун сая) төгрөгөөр баталсан боловч Зам тээврийн яамны Зам тээврийн хөгжлийн төвийн 2024 оны 09 дүгээр сарын 06-ны 385/2024 тоот магадлалын ерөнхий дүгнэлтээр гарсан төсөв болон Эрчим хүчний яамны Эрчим хүчний үндэсний төвийн 2024 оны 09 дүгээр сарын 18-ны 720/2024 тоот магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажсан "Дамжуулах шугамыг хүчитгэх, солих ажил"-ын төсвийн нийлбэрээр тус төсөл, арга хэмжээний нийт төсөв 8,687,295,649 (найман тэрбум зургаан зуун наян долоон сая хоёр зуун ерэн таван мянга зургаан зуун дөчин ес) төгрөг болсон байна.

Иймд тус төсөл, арга хэмжээний нийт төсөв өртөг нь захирамжаар батлагдсан төсөвт өртгөөс зөрүүтэй байгаа тул дараах ажлуудаар тендерийг зарлаж өгнө үү. Үүнд:

1. "Дамжуулах шугамыг хүчитгэх, солих ажил"
Төсөвт өртөг – 203,880,448 (хоёр зуун гурван сая найман зуун наян мянга дөрвөн зуун дөчин найм) төгрөг
2. "Авто замын ажил"
Төсөвт өртөг - 6,934,431,375 (зургаан тэрбум есөн зуун гучин дөрвөн сая дөрвөн зуун гучин нэгэн мянга гурван зуун далан тав) төгрөг
3. "Дулаан хангамжийн шугам сүлжээг хүчитгэх ажил"
Төсөвт өртөг - 369,378,814 (гурван зуун жаран есөн сая гурван зуун далан найман мянга найман зуун арван дөрөв)

Дээрх ажлуудын нийт төсөвт өртөг 7,507,690,637 (долоон тэрбум таван зуун долоон сая зургаан зуун ерэн мянга зургаан зуун гучин долоо) төгрөг.

1 дүгээр хавсралт: Зам, барилгын ажлын төсөв, 32 хуудастай.

2 дугаар хавсралт: Авто замын ажлын зураг, тайлбар бичиг, 154 хуудастай.

3 дугаар хавсралт: Магадлалын ерөнхий дүгнэлт /зам/, 11 хуудастай.

4 дүгээр хавсралт: Геодезийн тайлан, 17 хуудастай.

5 дугаар хавсралт: Геологийн тайлан, 35 хуудастай.

6 дугаар хавсралт: Магадлалын ерөнхий дүгнэлт /дамжуулах/, 4 хуудастай.

7 дугаар хавсралт: Дулааны төсөв, 10 хуудастай.

8 дугаар хавсралт: Дулааны зураг, 14 хуудастай.

9 дүгээр хавсралт: “Дамжуулах шугамыг хүчитгэх, солих ажил”-ын зураг, 22 хуудастай.

10 дугаар хавсралт: “Дамжуулах шугамыг хүчитгэх, солих ажил”-ын төсөв, 15 хуудастай.

11 дүгээр хавсралт: Техникийн шаардлага, 224 хуудастай.